

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Уур амьсгалын өөрчлөлтийн
тухай хуулийн төслийн талаар

Монгол Улсын уур амьсгалын өөрчлөлт, хүлэмжийн хийн ялгарлын өнөөгийн нөхцөл байдал

Монгол Улсын хүлэмжийн хийн ялгарал нь дэлхийн нийт хүлэмжийн хийн ялгаралд бага (0.09%) хувийг эзлэх боловч, нэг хүнд ноогдох хүлэмжийн хийн ялгарал нь дэлхийн дунджаас 2.7 дахин их юм. Монгол Улс 2014 онд нийт 34,482.73 мян.т CO₂ -эква. (газар ашиглалт, газар ашиглалтын өөрчлөлт ба ойн салбарыг тооцоогүй) ялгаруулсны 50.08% нь эрчим хүч, 48.51% нь хөдөө аж ахуй, 0.95% нь аж үйлдвэр, үлдсэн 0.46% нь хог хаягдлын салбараас ялгарсан байна. Хүлэмжийн хийн бүтцээр нь авч үзвэл 46.41%-ийг нүүрсхүчлийн давхар исэл буюу нүүрсхүчлийн хий (CO₂), 32.89%-ийг метан хий (CH₄), 20.42%-ийг азотлог исэл (N₂O), 0.28%-ийг гидрофторт нүүрстөрөгч (HFCs) тус тус эзэлж байна.¹

Монгол Улсын сүүлийн 80 гаруй жилийн хугацаанд агаарын температурын жилийн дундаж хэм 2.25°C-ээр нэмэгдсэн нь дэлхийн дундаж өөрчлөлттэй харьцуулахад өндөр үзүүлэлт юм. Сүүлийн 45 жилд хүйтэн өдрийн тоо дунджаар 15 хоногоор буурч, халуун өдрийн тоо 24 хоногоор нэмэгджээ. Дулааны улиралд орох хур тунадас буурч хуурайших хандлагатай байна².

Монгол улсын далайд гарцгүй газар зүйн байршил, агаарын температур нь эрс тэс, өндөр хэлбэлзэл, жилийн дундаж температур нь -8°C-ээс +6°C –ийн (зуны дундаж температур 10°C-26°C, өвлийн дундаж температур -15°C-аас -30°C) хооронд хэлбэлздэг, жилийн нийт хур тунадас нь говийн бүсэд 50 мм, нутгийн хойд уулархаг нутагт 400 мм ордог нь монголыг уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд илүү өртөмтгий, эмзэг байдалд оруулдаг байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн талаар 2009 болон 2014 онуудад хийсэн үнэлгээгээр³ монголын экосистем ихээхэн эмзэг, эдийн засаг нь мал аж ахуйгаас хамааралтай, хур борооны хэмжээнээс шуудхамааралтай газар тариалантай, хүн ам нь хурдацтай нэмэгдэж байгаа, уламжлалт нүүдлийн ахуйтай боловч хотжилтын хандлага давамгайлж байгаа зэрэг олон хүчин зүйл нь Монгол улсыг уур амьсгалын өөрчлөлтөд маш эмзэг, өртөмтгий болгож байна гэсэн дүгнэлт хийсэн байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлөл нь:

- (1) Усны хомсдол - өндөр уулсын цас, мөсөн голууд хайлж, гадаргын усны нөөц цөөрснөөр,
- (2) Цөлжилт - хөрсний болон газар, бэлчээрийн доройтол нэмэгдсэнээр,
- (3) Ойн экосистемийн доройтол - хортон шавж, түймрийн аюул ихэссэнээр
- (4) Ядуурал, хүнсний аюулгүй байдал нь байгалийн нөөц баялаг, хөдөө аж ахуй, газар тариалангийн нөөц, хомсдол үүссэнээр,
- (5) Хүний эрүүл мэндийн хохирол - экологийн тэнцвэрт байдлын алдагдал, байгаль орчны бохирдсоноос,
- (6) Биологийн олон янз байдлын доройтол нь дээрх сөрөг нөлөөллийн улмаас зарим төрөл зүйлийн ургамал, зэрлэг ан амьтан устаж, тоо толгой цөөрснөөр,

¹ Үндэсний тодорхойлсон хувь нэмэр тайлан 2019,

² Үндэсний тодорхойлсон хувь нэмэр тайлан 2019,

³ Монгол Улсын уур амьсгалын өөрчлөлтийн үнэлгээний тайлан 2009, 2014 он,

(7) Үер, ган, зуд, газар хөдлөлт зэрэг байгалийн гамшигт үзэгдлийн улмаас нийгэм, эдийн засгийн их хэмжээний хохирол, хор уршгийг үзүүлж байгаагаар тус тус илэрч байна.

Тухайлбал, судлаачдын тогтоосноор 1971 оны байдлаар нийт газар нутгийн 63%-д олон жилийн цэвдэг тархсан байсан бол 2016 онд 29.3% болсон байна. 2000-2015 оны хооронд нийт нуур цөөрмийн 21%, гол мөрний 12%, горхи булгийн 15% нь хатаж ширгэсэн гэсэн судалгаа байдаг. Гэхдээ мөсөн гол, цэвдгийн хайлалтын улмаас зарим газар булаг шанд эргэн сэргэх, шинээр гарах тохиолдол бас ажиглагдаж байна. Манай улсад хүчтэй салхи, цасан шуурга, аадар бороо, аянга цахилгаан, үер, ой хээрийн түймэр, ган, зуд зэрэг цаг агаарын гаралтай аюулт, гамшигт үзэгдэл жилд дунджаар 54 удаа тохиодог бөгөөд харин тэдгээрийн давтамж сүүлийн 20 жилд хоёр дахин нэмэгджээ⁴.

Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлөл, үр дагаврыг байгалийн нөөц, экосистемийн гол бүрэлдэхүүн болон нийгэм-эдийн засгийн гол салбаруудаар хураангуйлан тоймлосныг Уур амьсгалын өөрчлөлтийн үнэлгээний 2014 оны тайланд тусгажээ⁵. Үүнд өнөөгийн уур амьсгалын элементүүдийн өөрчлөлт, байгаль, нийгэм-эдийн засгийн салбарт гарсан гол нөлөөлөл, ирээдүйн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээний гол үр дүн, шаардлагатай авч хэрэгжүүлэх, арга хэмжээ, үйл ажиллагаа зэргийг оруулсан байна.

Монгол улсын уур амьсгалын нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн тоо баримт, мэдээллүүдээс үзэхэд Монгол орны нутаг дэвсгэрт бүх улирлын агаарын температур цаашид тогтвортой нэмэгдэж дулаарах, хур тунадас өвөл нэмэгдэх хэдий ч, зуны улиралд нэмэгдэхээргүй төсөөлөгдөж байгаа явдал нь ерөнхийдөө уур амьсгалын ган, хуурайшлыг улам эрчимжүүлж, манай орны байгаль, нийгэм-эдийн засгийн салбаруудад шууд ба шууд бус байдлаар нөлөөлөхөөр байна.

Олон улс дахь уур амьсгалын өөрчлөлтийн хууль, эрх зүйн зохицуулалт

Одоогоор нийтдээ 35 орон уур амьсгалын өөрчлөлтийн суурь хуультайгаас 16 нь Европын улсууд бөгөөд эдгээр улсууд нь хоорондоо улс төр, эдийн засаг, нийгмийн хөгжил ойролцоо, соёл шашин нь адилхан. Энэ нөхцөлийг харгалзан судалгаанд хамрагдсан орнуудыг Европын орнууд болон бусад орнууд гэсэн ангиллаар хувааж судаллаа.

1.Европын орнууд:

Европын орнуудын уур амьсгалын өөрчлөлтийн хуулиуд нь дараах нийтлэг шинжтэй. Нарийвчилсан судалгааг Их Британи, Герман, Австри улсуудын уур амьсгалын хуулийн хүрээнд хийсэн.

- Хуулийн зорилтдоо эсвэл эрх барих дээд байгууллагын үүрэгт НҮБ-ийн уур амьсгалын өөрчлөлтийн тухай суурь конвенцын зарчим, Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх явдлыг ямар нэгэн хэлбэрээр оруулдаг. Энэ нь бусад буурай хөгжилтэй орнуудтай харьцуулахад уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг шийдвэрлэх явцад дагалдан гарах бусад асуудлууд (ажилгүйдэл, ядуурал, дэд бүтцийн хүрэлцээгүй байдал, нийгмийн салбарын хангамж муу гэх мэт) харьцангуй бага байдагтай нь холбоотой.

- Зарим орнууд хэлэлцээрээр хүлээсэн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах ҮТХН-ийн амлалтаа хугацаатай хуулийн зорилт болгон оруулсан. Уур амьсгалын өөрчлөлтийн хууль нь давхар өөр асуудлуудыг шийдвэрлэх, зохицуулах

⁴ Үндэсний тодорхойлсон хувь нэмэр 2019,

⁵ Монгол Улсын уур амьсгалын өөрчлөлтийн үнэлгээний тайлан 2014,

шаардлагагүй учраас шууд амлалт руугаа чиглэдэг.

- Хуулиуд нь уур амьсгалын өөрчлөлтийн хууль гаргахтай холбоотойгоор шинэ нүсэр бүтэц бий болгоогүй. Өмнө нь уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр тодорхой үйл ажиллагааг бусад хуулиудын хүрээнд (эрчим хүч, хог хаягдал, байгаль орчин) явуулж байсан учраас байгуулсан алба, нэгж, бүтцээрээ дамжуулан шинэ хуулийн хэрэгжилтийг хангах бололцоо ихтэй.

- Хуулийг хэрэгжүүлэх бодлогын баримт бичгийн оронд ажлын тайлан гаргадаг. Амлалтаа зорилт болгож тодорхой хэмжих нэгж, хугацаатай хуульчилсан орнуудын хувьд хууль нь бодлогын баримт бичгийн үүргийг давхар гүйцэтгэдэг байх талтай.

2.Бусад улсуудын хууль

Бусад орнуудын судалгаанд Пакистан, Балба, Кени, Филиппин улсуудыг хамруулсан. Йордан улс Ойрх Дорнодын орнуудаас анхлан уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний бодлоготой болсон, мөн хуульгүйгээр энэ чиглэлд бодлого хэрэгжүүлэгч орон гэдгээр нь жишиг болгон судалгаанд оруулсан.

- Хуулийн зорилтдоо Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх явдлыг оруулаагүй. Харин НҮБ-ийн уур амьсгалын өөрчлөлтийн тухай суурь конвенц, олон улсын хэлэлцээрээр хүлээсэн үүргээ биелүүлэх гэсэн ерөнхий заалтаар томьёолдог. Энэ нь уур амьсгалын өөрчлөлтийн хүрээнд тухайн улсад шийдвэрлэх олон асуудлууд (ажил эрхлэлт, ядуурал, нутаг орны өөрийн соёл, дэд бүтцийн хүрэлцээ гэх мэт) шинээр гарч ирдэг.

- Хэлэлцээрээр хүлээсэн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах ҮТХН-ийн амлалтаа хуулийн дагуу парламент эсвэл засгийн газраар батлагдах бодлогын баримт бичигтээ оруулдаг. Амлалтаа хуульчлах нь олон улсын хэмжээнд заавал биелүүлэх үүрэг болох эрсдэлтэй, нөгөө талаар тухайн улсуудын улс төрийн нөхцөл байдал, улсынх нь хөгжлийн стратеги нөлөөлөх талтай.

- Уур амьсгалын өөрчлөлтийн хууль гаргахтай холбоотойгоор эрх барих дээд байгууллагын (Үндэсний хороо, комисс, зөвлөл) дор ажиллах ажлын алба шинээр байгуулдаг. Ихэнх орнууд өмнө нь уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр тодорхой үйл ажиллагааг авч хэрэгжүүлж байгаагүй учраас шинээр мэргэжлийн алба байгуулах хэрэгцээ үүсдэг.

- Тусгайлан сан байгуулдаг. Өмнө нь уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр далайцтай үйл ажиллагаа явуулаагүй мөн энэ зорилгоор хөрөнгө мөнгө төсөвлөж байгаагүй зэргээс үүдэн хуулиар сан байгуулах зайлшгүй шаардлага үүсдэг.

- Хуулийн хамрах хүрээ нь өргөн. Мөн хүчин төгөлдөр салбарын хуулиуд нь уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр зохицуулалт хийдэггүйгээс шинэ хуулиар салбаруудад олон тооны асуудал зохицуулахад хүрдэг байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн хуультай холбоотой ирээдүйн чиг хандлага:

Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой асуудлуудыг улс орнууд суурь хуулиар эсвэл бодлогын баримт бичгийн хүрээнд эсвэл эдгээрийн хослол байдлаар зохицуулах гэсэн нийтлэг 3 хэлбэр байна. Үүнээс бодлогын баримт бичгээр зохицуулах хэлбэр нь цаашид халагдах төлөвтэй. Уур амьсгалын өөрчлөлтийн суурь хууль гарснаар

(1) тухайн улсын олон улсын хэмжээнд авсан амлалтыг дотооддоо хуульчилдаг;

- (2) хуульчилснаар зорилт тодорхой болж биелэх боломж, магадлал ихэсдэг;
- (3) хууль баталснаар үндэсний хэмжээний эрх мэдэл бүхий байгууллага бий болж хуулийн хэрэгжилт сайжирна;
- (4) тухайлсан төсөв бүхий зориулалтын сан байгуулагдаж санхүүгийн эх үүсвэр нь шийдэгддэг;
- (5) уур амьсгалын асуудлыг дотоодын улс төрийн нөлөөллөөс хамгаалдаг гэсэн нийтлэг дүгнэлт хийж байна.

Цаашид дэлхийн уур амьсгалын өөрчлөлт сөрөг нөлөөлөл их үүсгэхийн хирээр улс орнуудын энэ чиглэлд авч байгаа арга хэмжээ, үйл ажиллагааны үр дүн хурцаар тавигдана. Энэ хүрээнд хийгдэх ёстой эхний ажил нь уур амьсгалын өөрчлөлтийн суурь хуулийг боловсруулж хууль тогтоох байгууллагаараа батлуулах явдал. Одоогоор уур амьсгалын өөрчлөлтийн хуулийг улс бүр заавал батлан гаргах үүрэг хүлээгээгүй, ийм шахалт байхгүй боловч олон улсын хэмжээнд энэ чиглэлд тухайлсан суурь хуультай байх нь илүү гэсэн чиг хандлага давамгайл байна. Уур амьсгалын өөрчлөлтийн хууль цаашдаа олон улсын хэмжээнд байнга яригдах сэдэв бөгөөд хуулийг хэрэгжүүлэх явдал нь тухайн улсын хувьд дэлхий нийтийн өмнө хүлээсэн үүргүүдийн нэг болох юм.

Иймд Монгол Улс уур амьсгалын өөрчлөлт, хүлэмжийн хийн ялгарлын өнөөгийн болон ирээдүйн стратегийн үнэлгээг холбогдох салбаруудаар гаргах, түүний үр дүнг үндэслэн хүлэмжийн хийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох зорилт, арга хэмжээ, үйл ажиллагааг хууль, бодлого, стратеги, төлөвлөлттэй уялдуулж хэрэгжүүлэх хууль, эрх зүйн тодорхой орчныг бий болох шаардлагатай байна.

Хууль санаачлагчийн зүгээс Монгол Улсын хувьд өнөөгийн нөхцөл, байдалтай уялдуулан Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг шинэ шатанд гаргаж, хууль, эрх зүйн тодорхой орчныг бүрдүүлэх зорилгын хүрээнд Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлуудыг өөрийн орны онцлог, дэлхий нийтийн чиг хандлагад нийцүүлэн тодорхойлж, олон улсын шинэлэг зохицуулалтыг нэвтрүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, түүнд дасан зохицох чадавхыг бүрдүүлэх, хүлэмжийн хийг бууруулах цогц бодлого хэрэгжүүлэхэд хууль эрх зүйн зөв, тогтвортой орчныг бий болгох зайлшгүй шаардлагатай гэж үзсэн бөгөөд Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн зохицуулалтын хувилбарыг сонгосон болно.

Холбогдох судалгааны хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар одоогийн тодорхойгүй байгаа эрх зүйн зохицуулалтуудыг тодорхой болгох, нэр томъёоны зөрүүг жигдлэх, олон улсын жишигт нийцсэн, практик шаардлагад тулгуурласан хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх буюу Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл боловсруулах нь зүйтэй гэж үзсэн байна. Тиймээс голлох зохицуулалтын асуудлыг судалгааны явцад гаргаж дараах асуудлуудыг хуульд тодорхойлох нь зөв гэж үзлээ. Үүнд:

- (1) Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, хүлэмжийн хийг бууруулах чиглэлд Монгол Улсын баримталж буй урт хугацаанд баримтлах Зорилтыг тодорхойлох;

- (2) Уур амьсгалын өөрчлөлтийн хүрээнд зохицуулах асуудлуудын хамрах хүрээг Алсын хараа, дунд хугацааны бодлогын зорилтууд болон ҮТХН-ийн баримт бичгүүдтэй уялдуулан хэрэгжүүлэх дунд хугацааны бодлогын баримт бичигтэй байх асуудлыг хуульчлах;

(3) Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг хариуцах төрийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, тэдгээрийн эрх үүрэг, хариуцлагыг тодорхойлох;

(4) Аж ахуйн нэгж, байгууллага, иргэд болон бусад байгууллагуудын эрх, үүрэг хариуцлагын тогтолцоог бий болгох;

(5) Нутгийн захиргааны байгууллагын чиг үүргийг тодорхойлох;

(6) Үндэсний хороо, салбар хоорондын - дэд хороо, орон нутагт - салбар хороо, шаардлагатай тохиолдолд ажлын хэсэг, төслийн баг байхаар зохицуулсан одоогийн зохицуулалтыг анхаарах, мөн Мэргэжлийн зөвлөлийг тусгайлан бүтцэд бий болгох;

(7) Хүлэмжийн хийн тооллого болон ҮТХН-ийн хэрэгжилтийг үнэлэх, тайлагнаж, хэмжих тогтолцоо, зохицуулалтыг бий болгох;

(8) Санхүүжилтийн тогтолцоо, Сангийн зохицуулалтыг тусгах, бий болгох;

(9) Мэдээллийн сан, ил тод байдал, түүний хэрэгжилтийг хангах.

Иймд дээр дурдсан нөхцөл байдал, судалгааны дүн, Монгол Улсын эрх зүйн үндсэн зарчим, олон улсын сайн туршлага, зарчмуудтай нийцүүлэн Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төслийг 9 бүлэгтэй хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөл нь дараах бүлгээс бүрдэнэ. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт хуулийн зорилго, уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, уур амьсгалын өөрчлөлтийн үйл ажиллагаанд баримтлах зарчим болон хуульд хэрэглэсэн нэр томъёоны тодорхойлолтыг тусгана.

Хоёрдугаар бүлэгт уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх төрийн байгууллагууд болох Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, холбогдох төрийн захиргааны төв байгууллын чиг үүрэг, төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны байгууллагын болон хүлэмжийн хийн бүртгэл хариуцсан байгууллагын эрх, үүргийг тусгана.

Гуравдугаар бүлэгт уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ, хүлэмжийн хийн үндэсний тооллого, уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, шинжилгээ, мэдээллийн суурь тогтолцоотой холбоотой харилцааг тусгана.

Дөрөвдүгээр бүлэгт уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох бодлого, Үндэсний дасан зохицох төлөвлөгөө, дасан зохицох арга хэмжээ, хохирлын үнэлгээ болон уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулахтай холбоотой зохицуулалтыг тусгана.

Тавдугаар бүлэгт уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, шингээлтийг нэмэгдүүлэх бодлого, арга хэмжээ болон Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн хэрэгжилттэй холбоотой харилцааг тусгана.

Зургаадугаар бүлэгт ногоон санхүүжилтийн эх үүсвэр, санхүүгийн хэрэгсэл, шалгуур, нийцэл, ил тод байдал, тайлагнал, баталгаажуулалттай холбоотой харилцааг тусгана.

Долоодугаар бүлэгт карбон зах зээлийн хэлбэр, карбон кредитийг үүсгэх, баталгаажуулах, бүртгэх, өмчлөх, шилжүүлэгтэй холбоотой харилцааг тусгана.

Наймдугаар бүлэгт уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой мэдээллийн сан, мэдээллийн тогтолцоо, ил тод байдал, тайлагнал, хяналт-шинжилгээ, үнэлгээтэй холбоотой харилцааг зохицуулна.

Есдүгээр бүлэгт хориглох үйл ажиллагаа, уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох зохицуулалтыг тусгана.

Хууль батлагдсанаар үүсэх нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль батлагдсанаар дараах эерэг үр дүн гарна. Үүнд:

1. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, дасан зохицох, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах талаар олон улсын өмнө хүлээсэн үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой хууль, эрх зүйн орчин бүрдэж хүлэмжийн хийн тооллого, тооцоолол, уур амьсгалын өөрчлөлтийн эмзэг байдал болон эрсдэлийн үнэлгээний нэгдсэн зохицуулалт бий болгоно.

2. Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой мэдээллийн санг бүрдүүлж, судалгаанд үндэслэсэн нэгдсэн бодлого төлөвлөлтөөр уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах болон дасан зохицох арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд шинжлэх ухааны үндэслэлтэй хариу арга хэмжээ авах боломж бүрдэнэ.

3. Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, шингээлтийг нэмэгдүүлэхтэй холбоотой Монгол Улсын хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд олон улсын болон төр, хувийн хэвшлийн салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, олон улсын механизмыг нэвтрүүлэх боломж бүрдэнэ.

4. Шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа, мэдээлэлд суурилсан бодлого, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх салбар хоорондын зохицуулалт боловсронгуй болж, Засгийн газар уур амьсгалын өөрчлөлтийн улмаас учрах эрсдэлийг удирдах, байгалийн гамшгаас сэргийлэхтэй холбоотой салбар дундын уялдаа холбоог сайжруулах, Монгол Улс Парисын хэлэлцээрт нэгдэн орсон улсын хувьд олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нөхцөл бүрдэнэ.

5. Карбон зах зээлийн кредит баталгаажуулах, арилжаанд оролцох нөхцөлийг бүрдүүлснээр карбон кредитийг эдийн засгийн эргэлтэд оруулж улс орны нийгэм, эдийн засагт эерэг нөлөөлөл үзүүлнэ.

6. Түүнчлэн, уур амьсгалын санхүүжилт, хөрөнгө оруулалтын тогтолцоог бүрдүүлэх замаар байгаль орчинд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтийг даван туулахад шаардлагатай санхүүжилтийн найдвартай, тогтвортой эх үүсвэрийг бүрдүүлэх боломжтой болно.

7. Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, шингээлтийг нэмэгдүүлэх, экосистемийн тэнцвэрийг хамгаалах бодлого, арга хэмжээний хэрэгжилт системтэй болно.

8. Хүлэмжийн хийн ялгарлын тэнцлийг хангах зорилтыг үе шаттай хэрэгжүүлэх, технологийн шинэчлэл, инновацыг дэмжих эрх зүйн орчин бүрдэнэ.

Хуулийг даган боловсруулах журам, дүрэм, аргачлалын тухайд:

- Засгийн газраас батлах журам
- Үндэсний зохицуулагч байгууллагын бүтэц, үйл ажиллагааны дүрэм
- Ил тод байдлын тайлагналын систем, Хяналт-шинжилгээ, үнэлгээний журам
- Карбон зах зээлийн хэрэгжилтийн журам
- Үндэсний бүртгэл, шилжүүлгийн журам
- ҮТХН-ийг боловсруулах, тайлагнах журам

- Үндэсний хүлэмжийн хийн ялгарлын тооллого хийх журам
- Мэдээлийн нэгдсэн сангийн үйл ажиллагааны журам зэрэг болно.

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад холбогдох хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар санал

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан болно.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Агаарын тухай, Газрын тухай хууль, Авто замын тухай, Барилгын тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай, Хот байгуулалтын тухай, Олон улсын гэрээний тухай, Төсвийн тухай, Эрчим хүчний хэмнэлтийн тухай, Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль, Тариалангийн тухай хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль төслийг Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн хамт боловсруулна.

-----oOo-----